



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар Д/137

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 07 дугаар сараас эхлэн нийт нутгаар усархаг аадар бороо орсны улмаас сумын төвийн засмал замын хажуу далан нурж улмаар засмал замаа эвдэх эрсдэл үүссэн учир зардалд 1.800.000 (нэг сая найман зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ХАТАНБААТАР